



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ХӨДӨЛМӨРИЙН ТӨВ БИРЖИЙН
Ц.ЭНХТУЯА ТАНАА

2014.03.07 № 1/06 ЧАГ-САГ/2014/39/СТГА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Хөдөлмөрийн төв биржийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Хөдөлмөрийн төв бирж нь ажиллагсад олгосон хоол, унааны мөнгийг цалингийн бүрэлдэхүүнд оруулан тооцсон боловч нийгмийн даатгал суутгасны дараах дүнгээс татвар суутган олгосон байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна", 15.1.1-т "үнэ төлбөргүй эсвэл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө", 15.1.3-т "бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор", 22 дугаар зүйлийн 22.1.4-т "шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр нь тодорхойлно", 26 дугаар зүйлийн 26.1.1-т "энэ хуулийн15.1-д заасан орлогын дүнд, мөн хуулийн 23.1-д заасан хувиар тус тус албан татвар ногдуулан, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.


2013 онд 84,241.0 мянган төгрөгийн шууд бус орлогоос 842.4 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгажээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Дутуу суутгасан 842.4 мянган төгрөгийг холбогдох татварын албанд нөхөн тайлагнаж төлж барагдуулахыг, биелэлтийг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөрийн төв биржийн дарга Ц.Энхтуяа, ерөнхий нягтлан бодогч Р.Жанлавцогзол нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын
Аудитор  Б.Сэржмядаг


Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн
захирал  Б.Пүрэвдулам

Аудитор  Б.Бямбадорж

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

Хөдөлмөрийн төв биржийн
дарга  Ц.Энхтуяа

Ерөнхий нягтлан бодогч
 Р.Жанлавцогзол

